



22130603



International Baccalaureate®
Baccalauréat International
Bachillerato Internacional

MONGOLIAN A: LITERATURE – STANDARD LEVEL – PAPER 1
MONGOL A : LITTÉRATURE – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1
MONGOL A: LITERATURA – NIVEL MEDIO – PRUEBA 1

Wednesday 8 May 2013 (morning)

Mercredi 8 mai 2013 (matin)

Miércoles 8 de mayo de 2013 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a guided literary analysis on one passage only. In your answer you must address both of the guiding questions provided.
- The maximum mark for this examination paper is [20 marks].

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez une analyse littéraire dirigée d'un seul des passages. Les deux questions d'orientation fournies doivent être traitées dans votre réponse.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est [20 points].

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un análisis literario guiado sobre un solo pasaje. Debe abordar las dos preguntas de orientación en su respuesta.
- La puntuación máxima para esta prueba de examen es [20 puntos].

Доорх хоёр зохиолоос зөвхөн нэгийг нь сонгож, хөтөч хоёр асуултын дагуу уран зохиолын талаас задлан тайлбарлаж бич.

1.

(Тайзны засал) Хөдөө говь тал газар буюу мөн хэсэг бага зэргийн ухаанууд үзэгдэнэ. Хүүхэн Гүндэгмаа ухаагийн нэгэн этгээдэд хонь хариулан юм оёж суугаад “Тоорой банди”-ийн аялгуугаар дуулахдаа:

Усны урсгалыг уруу газар татна даа
 Учирсан хоёрыг омогт тайж хүү дарна хө
 Шилийн цагаан өвсийг шинэхэн цас дарна хө
 Сэтгэлийн амраг хоёрыг шилэн жинст хүү дарна хө
 Замд ороод явбал заавал усан дээр орно доо хө
 Занаж бодоод явбал заавал нэг дийлнэ дээ хө гэх зэргээр дуулж сууна.

- 5 Бадарчин Чинаана нөгөө ухаагийн чанадад үүргийг задлан сууж байгаад Гүндэгмаагийн бүхий л байдлыг үзэж сонирхон сууна. Ийн байтал Соронзонгомбо нэг гартаа ташуур барьж, хэтэрхий самуун зан байдалтай гарч Гүндэгмаа дээр шууд очиж харилцан мэндээ мэдэлцэж,
 СОРОНЗОНГОМБООС – За хө чи, мөнөөх салахгүй гэдэг хар хүн чинь гэртээ одоо
 10 бий юу? Би та хоёрыг ердөө салгаж чадахгүй юм болов уу гэж санаж байсан юм.
 (хэмээн их л инээн тачигнана)
 ГҮНДЭГМАА – Амьд байвал дахиж нэг учрах цаг байлгүй дээ. Та нар нэг удаа доромжлон салгахаас бус хоёр дахин салгахгүй биз дээ.
 СОРОНЗОНГОМБО – Бид нар доромжлон явуулсан юм уу? Эзэн хааны эр цэрэгт
 15 дайчлагдсан юм биш үү? Харин чи энэ мэтийн үг олныг хэлэх ахул өөрийн биендээ зовлон хураах магадгүй биш үү дээ.
 ГҮНДЭГМАА – За, яахав дээ. Ямар учраас явуулсныг би мэдвээс барав даа. Яахав, хэт нь болох байлгүй дээ.
 СОРОНЗОНГОМБО – Хэт нь чи ер нь яадаг хүн бэ? Хирээ мэдэж адууныхаа хирээр
 20 хашигувал дээр байдаг юм шүү. Чи ер нь мэдэх үү, үгүй юу?
 ГҮНДЭГМАА – Бид нар хэдийгээр өөрсдийн хирээр байх боловч та бүхнээс хэтэрхий хилсдүүлж хохируулах нь та нарын эрх болох тул аргагүй дээ.
 СОРОНЗОНГОМБО – Чи одоо надтай энэ мэтийн хэгжүүн үг ярилцах хэрэггүй.
 Харин чи надтай эвлэж миний гэргий болж суугаад, энэ муу хонь хариулах ажлаасаа
 25 салж жаргахыг бодвол дээр байх. Би хэдийгээр тэнгэр угсаатан хүний үр хөвүүн боловч чамд баахан дурладаг юм даа. Чиний заяа чинь мэдэх юм даа.
 ГҮНДЭГМАА – Та ер нь хаашаа жигтэйхэн хүн бэ? Би хэрэв тантай суух ахул энэ хэдэн жилийн дотор суулгүй яахав дээ. Би ер нь өөрийнхөө хирээр, заяаныхаа хирээр хир таарах хүнтэй байхыг боддог. Тэгээд тантай сууж жаргах заяа хаа
 30 байна вэ дээ.
 СОРОНЗОНГОМБО – Илжигний чихэнд ус хийвч сэгсэрнэ, тос хийвч сэгсэрнэ хэмээхийн үлгэрээр чамд ямар сайхан үг хэлэвч ер тусгүй байна даа. Шууд албадан хүчирхэж байвал таарах заяатай хүн байлгүй дээ хэмээн (тачигнан инээнэ)
 ГҮНДЭГМАА – За, яахав. Энэ нэг удаадаа яасан ч та нарын эрх болох тул арга
 35 үгүй дээ. Гэвч алахгүй бол гайгүй байлгүй. Бололгүй дээ.

СОРОНЗОНГОМБО – Яана гэнэ ээ хө. Чамайг ер нь болохгүй бол алсан ч яахав дээ. Ер яасан ч яахав дээ хэмээн (гэнэт тачигнан инээж, “Байг даа, хөөрхий” хэмээн барин авч таалах хэмээхэд хүүхэн эсэргүүцэж харилцан тэмцэж гарахад) ухаагийн цаад талд

- 45 БАДАРЧИН ЧИНААНААС – Хүүе, та минь! Цаана чинь чоно хонинд орлоо! Туу, туу! хэмээн хэдэн удаа дуу гарахад Соронзонгомбо хүүхнийг тавьж ууртайгаар явна. ГҮНДЭГМАА – (Арай ядан салж дуу гарсан зүгт) Хонь минь хaa байна? хэмээн явахад цаанаас бадарчин түүний өмнөөс гарч ирээд харилцан мэндийг мэдэлцэж: ГҮНДЭГМАА – Чоно хaa байна? Хонь минь хaa вэ? хэмээхэд
- 50 БАДАРЧИН ЧИНААНА – (инээн) Үгүй, би үнэхээрийн ёстай чоно ирсэн хэмээсэн юм биш ээ. Хонь чинь энэ ард сайхан байна билээ. Би харин өөр янзын чоно хүнд давхиж байхыг үзээд аргагүй салгахын тулд тийнхүү хашгирсан. ГҮНДЭГМАА – (инээн) Үгүй. Та бас их сайн хүн ээ. Надад харин их тусыг хүргэв. Үнэхээрийн би тэр чононд бариулахад шахав. Энэ муу харгис феодалын хүү 55 намайг нөхрийн минь хамтаар их дарлаж зовоож байгаа юм. Тэгээд энэ өөрийн хэлж занаж авирлаж байгааг та бэлхнээ үзсэн буй за.
- БАДАРЧИН ЧИНААНА – Би чамайг ганцаар дуулж суухаас аваад одоо сая хүртэл чиний зовлонт байдлыг бүгдийг мэдэж, эцэст арга буюу тэсэхгүй болоод тийнхүү хашгирч түүнийг чамаас түр холдуулахын арга тэр боллоо шүү дээ.

Ши Аюуш, *Говийн хүүхэн Гүндэгмаа* (1934)

- (a) Бадарчин Чинааны дүрийн ач холбогдол юу вэ?
- (б) Жүжгийн энэ хэсгийн хэл найруулгын онцлогийг тайлбарла.

2.

- Өглөө бүр би
 Өвсний шүүдрээр цээжээ угаагаад
 Өглөө бүр би
 Өтгөн ой манангаар нүдээ арчдаг.
- 5 Нүүр биеэ цэцгээр сэвэхэд
 Нүцгэн эсийг шүлгийн сэрэл
 Сэлэнгэ мэт дайран урсдаг.
 Хөхөө, хэрээ,
 Хөхтүрүү, эрвээхэй
- 10 Аль нь ч надад ялгаагүй
 Адилхан ЭХ ОРОН.
 Харах нүд баясгах
 Хамгийн сайхан бугын урамдаан
 Хaa сайгүй арзганах
- 15 Халцархай далавчтай царцааны цархираа ч
 Хайрлан санах миний зүрхэнд
 Халуун аминаас тасарсан үрийн минь уйлаан шиг
 Хажиглах аргагүй өөрийн санагддаг.
 Цаашаахи учрыг нь мэдэхгүй ч гэлээ
- 20 Чагнах тусам нулимс ивлэдэг.
 Цас – өвлийн бороо юм.
 Цан хүүрэг – өвлийн манан юм.
 Хайрах жавар – өвлийн сэвшээ юм.
 Хацар алгадах шуурга – өвлийн зэрэглээ юм.
- 25 Ингэж би дотроо боддог
 Инээдтэй ч бай хамаагүй, хувьдаа үнэмшдэг.
 Чулуун дээр сандайлахад
 Чулуу надад “хайртай” гэж хэлэх шиг санагддаг.
 Хар модны гишүү хөлд хугарах нь
- 30 “Хайртай” гэж хашгирал шиг бодогдоно.
 Хавар бүр би ногооны үнэрт согтоно.
 Ханх тавих агь, гангын үнэр сороод
 Уушги минь цох мэт жижгэрч, халим мэт томорно.

Д Урианхай, Эх орны тухай бодол (1994)

- (а) Энэ шүлгийн хэсэгт төрсөн нутгийн гайхам сайхныг хэрхэн дүрсэлснийг тайлбарлан бич.
- (б) Энэ шүлэгт адилтгал, зүйрлэл, хүншүүллийн аргыг хэрхэн хэрэглэсэн талаар тайлбарлан бич.